

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ СУЛ ОРОН ТООНЫ ЗАР

2026 оны 05 дугаар сарын 18

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн бусад байгууллагад ажиллаж байгаа, зарлагдсан албан тушаалын тусгай шаардлагыг хангах төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах шаардлага:

- Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- Зарлагдсан албан тушаалтай адил төрөл, адил ангилалд ажилладаг байх;
- Зарлагдсан сул орон тооны албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх;

Бүрдүүлэх материал:

1. Хүсэлт;
2. Төрийн албан хаагчийн анкет (ТАЗ-ийн 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 521 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын 1-р хавсралтын дагуу);
3. Иргэний үнэмлэхийн хуулбар;
4. Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг (диплом), хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
5. Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
6. Нийгмийн даатгалын дэвтэр (Хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар, НДШ төлөлтийн цахим лавлагаа;
7. Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
8. Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас”-ны хуулбар;
9. Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн үнэлгээний хуудас;
10. Цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэний хувьд цэргийн үүрэгтний үнэмлэх;
11. Сахилгын шийтгэлтэй эсэх тодорхойлолт;
12. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–с татан авах/;
13. Төрийн албан хаагчийн ерөнхий болон тусгай шалгалт өгсөн нотлох баримтыг хавсаргах.

Материал хүлээн авах:

Хугацаа: 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 17:00 цаг хүртэл

Хүлээн авах цахим шуудан: tsetsegjargal@namem.gov.mn

Холбоо барих утас: 51- 264913

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ШИЛЖҮҮЛЭН, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ СУЛ ОРОН ТОО

2026 оны 05 дугаар сарын 18

Улаанбаатар хот

№	Байгууллагын нэр	Нэгжийн нэр	Албан тушаалын нэр	Орон тоо	Төрөл	Ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
1	ЦУОШГ	Улсын сүлжээний газар	Улсын сүлжээний газрын дарга	1	Эрхэлсэн түшмэл	T3-3	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	-цаг уур судлал /053210/; -уур амьсгал судлал /053212/; -ус судлал /053211/.	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх.	-Төрийн албанд 8-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх -Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 4-өөс доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх
2	ЦУОШГ	Урьдчилан мэдээлэх газар	Урьдчилан мэдээлэх газрын дарга	1	Эрхэлсэн түшмэл	T3-3	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	-цаг уур /053210/.	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх	-Төрийн албанд 8-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх -Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 4-өөс доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 2-оос

									доошгүй жил ажилласан байх -Урьдчилан мэдээлэх салбарт мэргэжлээрээ 6-өөс доошгүй жил ажилласан байх	
3	ЦУОШГ	Урьдчилан мэдээлэх газар	Архив, мэдээллийн сангийн хэлтсийн дарга	1	Ахлах түшмэл	ТЗ-4	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-хүрээлэн буй орчин судлал /052102/; -цаг уур судлал /053210/; -уур амьсгал судлал /053212/; -ус судлал /053211/; -өгөгдлийн сан, сүлжээний загварчлал /дизайн/ ба удирдлага /0612/; -програм хангамж, түүний хэрэглээ, хөгжүүлэлт ба шинжилгээ /0613/; -архив судлал /032202/.	Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх;	-Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх -Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх;
4	ЦУОШГ	Улсын сүлжээний газар	Цаг уурын улсын сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн	1	Дэс түшмэл	ТЗ-6	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-цаг уур судлал /053210/; -уур амьсгал судлал /053212/.	-шаардлагагүй.	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.

5	ЦУОШГ	Улсын сүлжээний газар	Хэмжих хэрэгсэл, хэмжил зүй, радарын сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн	1	Дэс түшмэл	T3-6	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-цаг уур судлал /053210/.	-шаардлагагүй.	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.
6	ЦУОШГ	Технологи, инновацийн хэлтэс	Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн	1	Дэс түшмэл	T3-6	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-цаг уур /053210/; -уур амьсгал судлал /053212/.	-шаардлагагүй.	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.
7	ЦУОШГ	Захиргааны хэлтэс	Эрх зүй, гэрээ хариуцсан ахлах мэргэжилтэн	1	Дэс түшмэл	T3-6	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-эрх зүй /0421/	-шаардлагагүй.	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.
8	ЦУОШГ	Захиргааны хэлтэс	Өргөдөл, гомдол, сургалт хариуцсан мэргэжилтэн	1	Дэс түшмэл	T3-7	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-эрх зүй /042101/; -төрийн удирдлага /041306/; -хүрээлэн буй орчин судлал /052102/; -цаг уур /053210/; -ус судлал /053211/; -архив судлал /032202/.	-шаардлагагүй.	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.
9	ЦУОШГ	Захиргааны хэлтэс	Санхүү, төсвийн төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан	1	Дэс түшмэл	T3-6	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	- санхүү/041201/; -нягтлан бодох бүртгэл/0411/; -эдийн засаг /0311/.	-шаардлагагүй.	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.

			ахлах мэргэжилтэн							
10	ЦУОШГ	Захиргааны хэлтэс	Олон талт хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн	1	Дэс түшмэл	ТЗ-6	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-олон улсын харилцаа /031202/; -гадаад хэлний орчуулга /023101/; -цаг уур судлал/053210/; -уур амьсгал судлал /053212/.	-шаардлагагүй.	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.